



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 04-р сарын 17-ны өдөр

Дугаар 2023-03/99

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.14 дэх заалт, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2023 оны А/188 дугаар захирамжийг заалтыг үндэслэн Ус ашиглуулагчийг төлөөлж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын ахлах мэргэжилтэн Д.Цэдэнсүрэн, Ус ашиглагчийг төлөөлж Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Улсын бүртгэлийн 9011751079, регистрийн 5121442 дугаартай “Эм Эл Ти Престиж” ХХК-ийн захирал Ц.Төмөрбаатар нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нөхөн тооцож, 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл нэг жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр . Гэрээний нөхцөл:

2.1. Ус ашиглах зориулалт: Жилд 10500.000 ширхэг тоосго үйлдвэрлэл, унд ахуйн хэрэгцээнд.

2.2 Ашиглах усны хэмжээ:

- Ундаргаар нь тооцоход 1 л/с ус авч ашиглах боломжтой.

1 ажилтан хоногт 20 л ус хэрэглэхэд 31 ажилчин, 1 хоногт 0,62м², 183 хоногт 113.46м³,

1000 ширхэг тоосго үйлдвэрлэхэд 0.4м³ ус хэрэглэнэ гэж үзвэл: 10.5 сая¹⁶ ширхэг тоосго үйлдвэрлэхэд 4200.0м³ ус ашиглана.

Уурхай дотоод замын тоосжилтод 24 удаа услахад 153.6 м³ ус ашиглана.

Нийт 4467.06м³

СХД-ийн ЗДТГ
Хууль, Эрх зүйн
Хэлтэс
№1

2.3. Усны чанар, найрлага: “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018” стандартын шаардлагад нийцэж байна.

2.4. Усны эх үүсвэрийн:

Байршил: Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Шар хөвийн хоолой

Солбицол: 47°52'19.68"N, 106°36'30.57"E

Барилга байгууламж: Унд ахуйн зориулалтаар гаргасан 120 м гүн өрмийн худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.

Тоног төхөөрөмж нэр марк: Худагт QJD-95 загварын усны насосыг 70 м гүнд суурилуулсан.

2.5 Стандартын шаардлага хангасан: Хангасан

2.6. Хаягдал усны хэмжээ, хаях цэгийн байршил:

Ажилчдын унд ахуйн хэрэглээнээс гарсан 20м³ багтаамжтай бохир усыг бетон доторлогоотой цооногт хуримтлуулж автоцистернээр зөөвөрлөн хотын бохирын шугамд нийлүүлдэг. Бохир ус татан зайлуулах гэрээг “Маргад эрдэнэ уул” ХХК-тай хийж гүйцэтгэдэг.

2.7. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Байхгүй.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөцийн бохирдлоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: Байхгүй.

2.9. Усны тоолуурын: Загвар, нэр, дугаар: ALS загварын 206930 дугаартай усны тоолуурыг суурилуулсан.

Тоолуурын тоо: 1

Тоолуур баталгаажуулалтын гэрчилгээ олгосон байгууллага огноо: Стандартчилал, хэмжил зүйн газар, 2021 оны 08-р сарын 30-ны өдөр

Тоолуурын заалт: Тоолуурын заалт 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 01043 м³.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 2023 оны усны нөөц ашигласны төлбөрийг “Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай”, Монгол улсын Засгийн Газрын 2011 оны 302, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай”, “Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн 2023 оны 12 дугаар сарын 25-ний дотор тоолуурын заалтаар тооцож /1м³ ус 188,8 төг/ төлнө.

Гурав. Талуудын эрх үүрэг.

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаархи дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Усан орчин ашиглуулагчийг төлөөлж:

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн
Ахлах мэргэжилтэн Д.Цэдэнсүрэн

Байгаль орчин, ногоон байгууламж
хариуцсан мэргэжилтэн

С.Сүхцоож

Хаяг: Сонгинохайрхан дүүргийн

27 дугаар хороо

Харилцах утас: 70173213

Ус ашиглагчийг төлөөлж:

“Эм Эл Ти Престиж” ХХК-ийн
захирал Ц.Төмөрбаатар

Ц.Төмөрбаатар

Хаяг: Сонгинохайрхан дүүргийн
32 дугаар хороо

Харилцах утас:

99116535, 99011583